



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 11 өдөр

Дугаар

A/44

Амардалай

Зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", "ж", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 12 дугаар хуралдааны шийдвэр, сумын Онцгой комиссын 09 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг: Коронавирус (Ковид-19)-ын цар тахал батлагдсантай холбогдуулан 2021 оны 04 дүгээр сарын 11 ны өдрийн 14.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 14 ны өдрийн 14.00 цаг хүртэл аймаг, сумаас орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж, хяналтын цэгийн үйл ажиллагааг 1-ээр нэмэгдүүлсүгэй.

Хоёр: Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд сумаас орох гарах хөдөлгөөнийг хязгаарлаж, архи, согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 04 дүгээр сарын 12 ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 15 ны өдрийн 06.00 цаг хүртэл хугацаанд хориглосугай.

Гурав: Хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00-18.00 цагийн хооронд байхаар тогтоож, бусад үйл ажиллагааг хязгаарлаж, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/-т даалгасугай.

Дөрөв: Эмийн сан, Эрүүл мэндийн төв, Шатахуун түгээх станц, ус түгээх цэг, хүнсний дэлгүүрүүдийн үйл ажиллагааг хэвийн үргэжлүүлж, хяналт тавьж ажиллахыг ЭМТ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Мөнхтуяа/-д даалгасугай.

Тав: Дээрх хугацаанд албан байгууллага, аж ахуйн нэгж, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчны ариутгал, халдваргүйтгэл хийж, гүйцэтгэх хуваарийг батлуулж ажиллахыг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, эрүүл ахуйн халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг ЭМТ-ийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Мөнхтуяа/, Сургуулийн эмч /Ш.Должин/, Цагдаагийн Хэсгийн төлөөлөгч /Л.Отгонбаатар/, Багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

Зургаа: Сумын төвд хөдөлгөөнд оролцох автомашинуудыг сумын Онцгой комиссын шуурхай штабын тусгай зөвшөөрлөөр хөдөлгөөнд оролцуулахыг Штабын дарга /С.Нарантунгалаг/-т үүрэг болгосугай.

488010 124

Долоо: Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хичээл сургалтын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 11 ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25 ны өдрийн 00.00 цаг хүртэл хязгаарлаж, халдвар хамгааллын дэглэмийн хүрээнд дотуур байрны хүүхдүүдийг орон гэрт нь хүлээлгэж өгөхийг Сургуулийн захирал /А.Мөнхбаатар/-т даалгасугай.

Найм: Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төвийн ажиллах цагийн хуваарийг 09,00-16,00 цаг, Засаг даргын Тамгын газар болон Эрүүл мэндийн төвийн ажиллах цагийн хуваарийг 09,00-18,00 цаг байхаар тогтоосугай.

Ёс: Хөл хорио тогтоосон хугацаанд хууль тогтоомжийг мөрдөж онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлж, халдвар хамгааллын дэглэмийг баримтлахыг сумын нийт иргэдэд уриалсугай.

Арав: Оршуулга, буяны ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул оролцох хүний тоонд хязгаарлалт тогтоож, зохион байгуулах талаар иргэдэд заавар зөвлөмж өгч, хяналт тавьж ажиллахыг Онцгой комиссын Штабын дарга /С.Нарантунгалаг/-т үүрэг болгосугай.

Арван нэг: Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч /Л.Золжаргал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



М.БАЯРСҮХ